

ХОЁРДУГААР БҮЛЭГ

**ХОРТ ХАВДРААС
СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ
БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН
ОРЧИН**



2.1 ХОРТ ХАВДРААС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ТҮҮХЭН ТОВЧООН, 1961-2021 ОН

Монгол улсад хавдраас сэргийлэх, хянах ажил төрийн тогтвортой бодлогын хүрээнд зохицуулагдаж, хэрэгжиж ирсэн түүхтэй билээ. Улс орны хөгжлийн үе шат, эрүүл мэндийн салбарын бодлого, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж, хүн амын өвчлөл, нас баралтын байдал, хэтийн төлөв

хандлага зэрэг олон хүчин зүйлсэд тулгуурлан төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг боловсруулж хэрэгжүүлж ирсэн бөгөөд дээрх бодлогын хүрээнд хавдар судлалын салбарын бодлогыг үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлсэн түүхтэй (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Хавдар судлалын асуудлыг Монгол улсын хууль, эрх зүй, бодлогын түвшинд шийдвэрлэсэн байдал, 1961-2021 он

Он	Хууль, бодлогын бичиг баримтын нэр	Хавдар судлалд хамаарах заалт, арга хэмжээ	Хүрсэн үр дүн
1961 он	Эрүүлийг Хамгаалах Яамны сайдын 24 тоот тушаал	<ul style="list-style-type: none"> Хотын 3-р больницын поликлиникт 7 хоногт 2 удаа 2 цагаар онкологийн үзлэг хийх кабинетыг байгуулсан байна. Савны өмөн үү өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт таних зорилгоор 18-аас дээш насны эмэгтэйчүүдийг жилд 1-2 удаа үзлэгт тогтмол хамруулах арга хэмжээг зохион байгуулахыг больницуудын дарга нарт даалгажээ. 	<ul style="list-style-type: none"> Өмөн үү өвчнийг илрүүлж эмчлэх, анхны диспансерийн эхлэл тавигдсан Эрт илрүүлэх үзлэгийн эхлэл тавигдсан
1961 он	12-р сарын 25-ны өдөр "Улсын цацраг туяа эмнэлэг" байгуулав	Тус эмнэлэг нь, мэс засал, эмэгтэйчүүд, туяа эмчилгээний 45 ор бүхий хэвтүүлэн эмчлэх тасаг, клиник, эд эсийн лаборатори, амбулатори, эмийн сан, захиргаа гэсэн 5 нэгж, үндэсний 5 эмч, ЗХУ-ын мэргэжилтэн 4 эмчтэйгээр ажиллаж эхлэв.	Монгол улсад хавдар судлалын алба үүсэн байгуулагдав.
1968 он	БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн (СнЗ) 341-р тогтоол, ЭХЯ-ны сайдын 612 тоот тушаал	Хавдар судлалын хөдөлгөөнт байнгын бригадыг байгуулж, хүн амын дундаас хавдрын урьтал өвчин, хорт хавдрыг эрт илрүүлэх ажлыг эхлүүлэв.	Урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн суурь тавигдав.
1971 он	ЭХЯ-ны сайдын 160 тоот тушаал	Хорт хавдрын өвчлөл, нас баралтыг бүртгэх журам батлав	Хорт хавдрын бүртгэлийн суурь тавигдсан.

1981 он	БНМАУ-ын СнЗ-ийн 6 дугаар сарын 26-ны өдрийн 198 тоот тогтоол	ЭХЯ-ны харьяа 200 ортой "Улсын хавдар судлалын төв" байгуулав.	Хавдар судлалын төвийг сургалт, эрдэм шинжилгээ эрхлэх, лавлагаа тусламж үзүүлэх төв болгон өргөжүүлэв.
1982 он	ЭХЯ-ны сайдын 3 дугаар сарын 19-ны өдрийн 62 тоот тушаал	Аймаг, хот, районы хавдар судлалын тасаг, кабинет ажиллах зааврыг батлав.	Аймаг, дүүргийн хавдрын кабинет байгуулагдав.
1997 он	Монгол улсын Засгийн газрын 3-р сарын 26-ны өдрийн 80-р тогтоол	Хорт хавдартай тэмцэх үндэсний анхны хөтөлбөр батлав.	ЗГ-ын дэргэд хорт хавдартай тэмцэх үндэсний зөвлөл, аймаг, хотод салбар зөвлөлүүдийг байгуулав.
2005 он	Монгол улсын Засгийн газрын 246 тоот тогтоол	"Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний анхны хөтөлбөр батлагдав.	Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах анхны хөтөлбөр амжилттай хэрэгжсэн.
2007 он	ЭМС-ын 137 дугаар тушаал	Хавдар судлалын үндэсний төвийн дүрэм, бүтцийг шинэчлэн батлав.	Хавдрын лавлагаа тусламж үйлчилгээ үзүүлэх, хавдраас сэргийлэх, хянах үндэсний бодлогыг удирдан зохицуулах, сургалт, эрдэм шинжилгээ эрхлэх үндэсний төрөлжсөн мэргэжлийн лавлагаа төв болж өргөжив.
2007 он	ЭМС-ын 242 тоот тушаал	Орон нутагт хавдрын хими эмчилгээ хийх журам батлагдав.	Аймаг, дүүргийн эмнэлэгт хавдрын хими эмчилгээ хийх суурь тавигдав.
2008 он	ЭМС-ын 210 тоот тушаал	"Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөр, 2008-2013 он батлагдав.	Хорт хавдраас сэргийлэх, хянах үйл ажиллагааг цогцоор нь төлөвлөж амжилттай хэрэгжүүлсэн.
2009 он	МУ-ын Засгийн газрын 254 тоот тогтоол	Хавдар Судлалын Үндэсний Төвийг МУ-ын хүний гавьяат эмч Намхай-Очирын Нямдаваагийн нэрэмжит болгожээ.	МУ-ын хүний гавьяат эмч Н.Нямдаваагийн нэрэмжит Хавдар судлалын үндэсний төв боллоо.
2010 он	ЭМС-ын 292 тоот тушаал	Аймаг, дүүрэгт хавдрын хими эмчилгээ, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний чадавхийг бэхжүүлэхээр заасан.	Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт хүн амын тооноос хамаарч 10-15 ортой хавдрын тасаг байгуулж эхэлсэн.
2011 он	ЭМС-ын 5 дугаар сарын 11-ны өдрийн 168 тоот тушаал	Умайн хүзүү, хөхний өмөнгийн эмнэлзүйн удирдамж	Умайн хүзүү, хөхний хорт хавдрын эрт илрүүлгийн тогтолцооны суурь тавигдсан.
2012 он	ЭМС-ын 3 дугаар сарын 12-ны өдрийн 76 дугаар тушаал	"Умайн хүзүү, хөхний өмөнгийн илрүүлэг, эргэн дуудах тогтолцооны удирдамж", "Хорт хавдрыг бүртгэх удирдамж",	Эрт илрүүлгийн үзлэгийг бүртгэх маягт, мэдээний урсгал, бүртгэлийн www. screening.gov.mn програм хангамжийг нэвтрүүлсэн. Үндэсний хэмжээнд хүн амд суурилсан хавдрын бүртгэлийн тогтолцоо бүрдсэн.

2014 он	Засгийн газрын 34 тоот тогтоол	Амьдралын буруу хэвшилтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хоёр дахь хөтөлбөр	Хорт хавдраас сэргийлэх, хянах ажлыг 2014-2017 он хүртэл хэрэгжүүлсэн.
2014 он	ЭМС-ын 431 дугаар тушаал	Хорт хавдрын бүртгэл тандалтын нэр томьёо, бүртгэлийн маягт, бүртгэх заавар, хавдрын бүртгэлийн ажилтаны ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлав.	Хорт хавдрын бүртгэлийн CANREG-MON програм хангамжийг нэвтрүүлэв
2015 он	ЭМС-ын 351 дугаар тушаал	Хорт хавдрын тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, аймаг дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудад хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар тусгажээ.	Аймаг, дүүргийн эмнэлгийн хавдрын тасгийн үйл ажиллагааг өргөжүүлж, хавдрын эрт илрүүлгийн тогтолцоог чадавхижуулсан.
2016 он	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 07 тоот тогтоол	Хорт хавдрын мэс засалд шаардагдах өндөр өртөгтэй зарим эмнэлгийн хэрэгслийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр заав.	Хорт хавдрын өндөрт өртөгтэй мэс заслын эмнэлгийн хэрэгслэлийн анх удаа даатгалаас санхүүжүүлэх эхлэл тавигдав.
2016 он	МУ-ын УИХ-ын 19 дүгээр тогтоолоор	Монгол Улсын "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" бодлогын баримт бичигт 2016-2030 онд хүн амын хорт дадал, зуршлыг бууруулж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах тухай зорилтыг дэвшүүлэв.	Хорт хавдрын эрт илрүүлэг тогтолцоог бүрдүүлэх замаар элэг, умайн хүзүү, хөхний хорт хавдрын нас баралтыг бууруулах зорилт дэвшүүлсэний үр дүнд умайн хүзүүний хавдрын эрт үе шатандаа илрэх хувь 59,3% болж, 5 болон түүнээс дээш жил амьдрах хугацаа 59,3% болсон.
2017 он	МУ-ын Засгийн газрын 112-р тогтоол	"Элэг бүтэн монгол 2017-2020" үндэсний хөтөлбөр батлагдав.	хепатитийн С, В вирусийн эмчилгээг нэвтрүүлж, эмчилгээний болон шинжилгээний зардлыг ЭМДС хариуцаж байна.
2017 он	МУ-ын Засгийн газрын 24 дүгээр тогтоол	"Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого 2017-2026" <ul style="list-style-type: none"> • нотолгоонд суурилсан шинэ технологийг нэвтрүүлэх, • эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн зохистой тогтолцоог бүрдүүлэх • монгол хүний дундаж наслалтыг уртасгах Урт хугацааны зорилт дэвшүүлэв. 	2026 он гэхэд 10000 хүн амд ноогдох хорт хавдрын шалтгаант нас баралтыг 9.0 промил хүртэл бууруулах, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт хамрагдалтыг 80%-д хүргэн нэмэгдүүлэх зорилго дэвшүүлэн хэрэгжиж байна.
2017 он	МУ-ын Засгийн газрын 9 дүгээр сарын 27-ны өдрийн 289 дүгээр тогтоол	"Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр 2017-2021" батлагдав.	Хэрэгжиж байна Дэлгэрэнгүйг энэхүү бүлгийн 2.2 дэд бүлгээс харна уу.

2018 он	ЭМС-ын 3 дугаар сарын 16-ны А/82 тоот	Умайн хүзүүний хорт хавдрын өвчлөл, нас баралтыг бууруулах зарим арга хэмжээний тухай" тушаал батлагдав.	Умайн хүзүүний хорт хавдрын өвчлөл, нас баралтыг бууруулах Нэгдсэн Үндэстний Байгууллагын хамтарсан Глобал хөтөлбөр 2018-2021-ийг Монгол улсад хэрэгжүүлж байна.
2018	ЭМС-ын А/420 тоот тушаал	Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамруулах тухай,	Хавдрын эрт илрүүлэг үзлэгийг ЭМДС-гаас санхүүжүүлж эхэлсэн.
2019 он	УИХ-ын 10 дугаар сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдааны шийдвэр	Эрүүл мэндийн тухай хууль нэмэлт өөрчлөлт оруулав. "Хорт хавдрын эрт илрүүлэх үзлэг оношилгоо"ны тухай нэмэлт өөрчлөлт оров.	Монгол улсын иргэнийг хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд түүний нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн товлосон хугацаанд хамруулах, зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх тухай заалт орсон бөгөөд үр дүнд нь хавдрын эрт илрүүлгийн багцуудыг тодорхойлж, ЭМДС-гаас зардлыг нь дааж байна.
2020 он	УИХ-ын 8 дугаар сарын 28-ны өдрийн хурлын шийдвэр	Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн "Даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай" зүйлд хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээний зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тухай нэмэлт өөрчлөлт оров.	Хуулийн заалт хэрэгжиж байна.
2020 он	УИХ-ын 8 дугаар сарын 28-ны өдрийн 24 дүгээр тогтоол	Засгийн газрын 2020-2024 оны Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд <ul style="list-style-type: none"> • "Хавдрын эсрэг арга хэмжээ"-г хэрэгжүүлэх, • ХСҮТ-2 салбар эмнэлгийг байгуулахаар шийдвэрлэв. 	ЭМС-ын 2021 он 6 дугаар сарын 10-ны өдрийн А/360 тоот тушаалаар "Хавдрын эсрэг арга хэмжээний 2021-2024 оны төлөвлөгөө"-г батлан хэрэгжүүлж байна
2020	ЭМС-ын оны 12 сарын 30 өдрийн 641 дугаар тушаал	"Умайн хүзүүний хорт хавдрын эмнэл зүйн цогц заавар"-ыг шинэчлэн батлав.	Умайн хүзүүний хорт хавдрын урьдчилан, сэргийлэлт, эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээ, хяналтын асуудлыг цогцоор нь тусгаж шинэчлэн боловсруулж хэрэгжүүлж эхэлсэн.
2021 он	ЭМДҮЗ-ийн 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн" 03 тоот тогтоол	Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журмыг батлав.	Хорт хавдрын мэс засал, химийн бай эмчилгээ болон туяа эмчилгээний зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувь хариуцаж байна.

2021 он	ЭМС-ын 6 дугаар сарын 10-ны өдрийн А/360 тоот тушаалаар	Хавдрын эсрэг арга хэмжээний 2021-2024 оны төлөвлөгөөг батлав.	Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн тогтолцоог бүрдүүлэх, тусламж үйлчилгээг тэлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, эрдэм шинжилгээ судалгааны ажлыг өргөжүүлэх, хавдрын бүртгэл, тандалт, хүний нөөцийг чадавхижуулах зэрэг асуудлыг цогцоор хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.
2020 он	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 52 дугаар ТОГТООЛ	Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлэн эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх зорилт дэвшүүлэв.	Монгол хүний эрүүл мэндийг хамгаалах асуудлыг цогцоор нь шийдэх зорилтууд дэвшүүлж, энэхүү урт хугацааны бодлогын хүрээнд хорт хавдраас сэргийлэх, хянах ажил төлөвлөгдөн хийгдэж байна. Одоо хэрэгжиж буй бодлого, хөтөлбөрийн талаарх мэдээллийг энэ бүлгийн 2.3 дэд бүлэгт дэлгэрэнгүй оруулав.
2019 онд	Эрүүл мэндийн даатгалын тухай хууль	Эрүүл мэндийн тухай хуулинд "Хорт хавдрын эрт илрүүлэх үзлэг оношилгоо"-ны тухай нэмэлт өөрчлөлт орсон	Энэхүү хуулийн заалт нь ЭМД-ын тухай хууль, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бусад баримт бичгүүдэд тусгалаа олж хавдрын эрт илрүүлгийн үзлэг шинжилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцаж байна. Хавдрын бүх төрлийн тусламж үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувь хариуцах болсон нь өвчтөн санхүүгийн дарамтгүйгээр авах боломж бүрдсэн юм.

2.2 ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ

2.2.1 Үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт: 2011-2021 он

Монгол улс "Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах талаарх НҮБ-ын Тунхаглал", ДЭМБ-ын "Халдварт бус өвчнөөс сэргийлэх дэлхий дахины үйл ажиллагааны төлөвлөгөө"-тэй уялдуулан хорт хавдраас, сэргийлэх, хянах бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлэн хэрэгжүүлж ирсэн.

Монгол улсын Засгийн газраас 2008-2013 онд "Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр, 2014-2017 онд "Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд "Хорт хавдраас сэргийлэх хянах дэд хөтөлбөр" болон "Элэгний хорт хавдрыг

эрт илрүүлэх стратеги"-ийг амжилттай хэрэгжүүлсэн нь хорт хавдраас сэргийлэх, хянах ажилд томоохон хувь нэмэр оруулсан.

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 289 дугаар тогтоолоор "Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр",

Засгийн газрын 2017 оны 112 дугаар тогтоолоор "Элэг бүтэн Монгол үндэсний хөтөлбөр"-ийг батлан хэрэгжүүлж эхэлсэнээр өмнөх хөтөлбөрүүд хүчингүй болсон бөгөөд дээрх 2 үндэсний хөтөлбөрийн хүрээнд хорт хавдраас сэргийлэх, хянах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Амьдралын буруу хэвшилтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хоёр дахь хөтөлбөр

"Амьдралын буруу хэвшилтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хоёр дахь хөтөлбөр"—ийг 2014-2021 онд хэрэгжүүлэхээр Засгийн газрын 2014 оны 34 тоот тогтоолоор баталсан. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ХСҮТ нь "Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөр"-ийг боловсруулж ЭМС-ын сайдын 2014 оны 412 дугаар тушаалаар батлуулан хэрэгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн хувьд удирдан 2015-2020 онд амжилттай хэрэгжүүллээ.

"Хорт хавдраас сэргийлэх, хянах" дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдах хороог Эрүүл мэндийн сайдын 2010 оны 176 дугаар, 2012 оны 426 дугаар тушаалаар тус тус байгуулсан бөгөөд удирдах хороо жилд 2-оос доошгүй удаа хуралдаж, хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлыг хэлэлцэж, тулгамдаж байгаа асуудлыг тодруулж, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээг төлөвлөн биелэлтийг нь хянаж ажиллажээ.

Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нараар ахлуулсан салбар хороод орон нутагт дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг

хариуцан ажиллаж байлаа. Хөтөлбөрийн хүрээнд хорт хавдраас сэргийлэх, хянах анхдагч болон хоёрдогч урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэг, хорт хавдрын оношилгоо, эмчилгээ, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ, хавдрын бүртгэл мэдээллийг боловронгуй болгож эрчимжүүлэх ажлуудыг хэрэгжүүлжээ.

Хорт хавдрын сэргийлэлт, хяналтыг сайжруулах зорилгоор Улаанбаатар хотын 9 дүүргийн эрүүл мэндийн төвд хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж, эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулахад шаардлагатай хүний нөөц, эм, урвалж, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн судалгааг хийв. Хяналт, үнэлгээн дээр үндэслэн Нийслэлийн эрүүл мэндийн газартай хамтран дүүргийн эмч нарыг зонхилон тохиолдох хорт хавдрын урьдал өвчний оношилгоо, эмчилгээ, эрт илрүүлэг, дэмжих тусламж үйлчилгээний чиглэлээр сургах, чадавхижуулах талаар хамтын ажиллагааны гэрээг 4 жилийн хугацаагаар байгуулан ажиллаж байжээ.

"Элэг бүтэн монгол" үндэсний хөтөлбөр, 2017-2020

Засгийн газрын 2017 оны 112 дугаар тогтоолоор "Элэг бүтэн монгол" үндэсний хөтөлбөрийг батлан 2 үе шаттайгаар 2017-2020 онд хэрэгжүүлсэн.

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь хүн амын дунд гепатитийн вирусын халдварын тархалтыг хязгаарлан, гепатитийн С вирусын халдварын шинэ тохиолдлыг 2020 он гэхэд таслан зогсоох, гепатитийн вирусээс үүдэлтэй элэгний архаг үрэвсэл, хатуурал, хорт хавдрын шалтгаант нас баралтыг эрс бууруулахад чиглэсэн.

Шийтгэл

"Элэг бүтэн Монгол" үндэсний хөтөлбөрийн хүрээнд гепатитийн вирусийн халдвар илрүүлэх шинжилгээнд эрүүл мэндийн даатгалтай нийт **929129** иргэн хамрагдсан нь 15-аас дээш насны хамрагдвал зохих хүн амын 60.6 хувийг эзэлжээ.



Иргэдэд санхүүгийн дарамтгүйгээр оношилгоо, эмчилгээний асуудлыг шийдвэрлэхийн тулд Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хамтран “Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоонд

хамруулах журам” боловсруулж, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор хепатитийн В, С вирусийн шинжилгээ, С вирусийн идэвхжлийг тогтоох шинжилгээний зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлсэн байна.

Шилтгээ

Эрүүл мэндийн даатгалын сангаас С вирусийн таван нэрийн эмийг хайрцаг тутамд нь 210,0 мянган төгрөгөөр, нэг курс эмчилгээний зардлыг үргэлжлэх хугацаанаас хамааран 630,000-аас Тсая 260,0 мянган төгрөгөөр хямдруулан олгож байна. Эрүүл мэндийн даатгалын сангаас шинжилгээний зардалд 6,3 тэрбум төгрөг, С вирусийн эмчилгээний зардалд 9,6 тэрбум төгрөг зарцуулжээ.

УИХ-ын ээлжит бус чуулганаар Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэх явцад 2020-2024 онуудад “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлэх тухай УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэнгийн саналыг нийт гишүүдийн 73.1 хувь дэмжиж, Засгийн газрын

2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт албан ёсоор тусгагдсан байна.

Хөтөлбөрийн хүрээнд мөн адил гепатитийн вирусын эрт илрүүлэг, шинжилгээ, эмчилгээ үргэлжлэхээс гадна гепатитийн Д вирусын халдвартай 100 мянган иргэдийг эмчилгээнд хамруулахаар тусгажээ.

Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 2017-2021

Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 289 дугаар тогтоолоор “Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эргэн дуудах тогтолцоог бэхжүүлэх, хавдрын тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хавдрын бүртгэл тандалтыг чадавхижуулах үйл ажиллагаа тусгагдан хэрэгжсэн билээ.

Мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хавдар судлалын салбарт хийгдсэн эрдэм шинжилгээ судалгааны ажлуудын үр дүнд тулгуурлан умайн хүзүүний хорт хавдрын эмнэлзүйн цогц хөтөлбөр боловсруулан 2020 онд ЭМС-ын тушаалаар батлан хэрэгжүүлж байна.

Аймаг, дүүргийн хавдрын тусламж үйлчилгээний чадавхийг сайжруулах зорилгоор 2011-2021 онд 66 хавдар судлаач эмч, 31 хөнгөвчлөх эмчилгээний эмч,

105 хавдрын сувилагч, 35 эмчийг хими эмчилгээний нарийн мэргэжил эзэмшүүлэх сургалтад хамруулж төгсгөсөн. Хавдрын мэс заслын тусламж үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор ХСҮТ нь хавдрын мэс заслын мэргэжил дээшлүүлэх сургалтыг 2014 оноос эхлэн зохион байгуулж 80 эмчийг хавдрын мэс заслын нарийн мэргэжил олгосон бөгөөд тэдгээр эмч нар аймаг, дүүрэгт улс, хувийн хэвшлийн эмнэлгүүдэд ажиллаж байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд хавдрын тусламж үйлчилгээнд нэвтэрсэн нэг томоохон үр дүн нь хавдрын туяа эмчилгээнд хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологи болох шугаман хурдасгуур нэвтэрсэн • Хавдрын мэс засал эмчилгээний чадамжийг дурангийн болон элэг шилжүүлэн суулгах чиглэлээр хөгжүүллээ. Тухайлбал дурангийн аргаар нойр булчирхайн зүүн тайралт хийх мэс засал эмчилгээг 2015 онд, хорт хавдартай өвчтөнд элэг шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээг 2018 онд нутагшуулснаар нойр булчирхай, элэгний хорт хавдар

оношилогдсон өвчтөнүүд олон улсын жишигт нийцсэн тусламж үйлчилгээг өөрийн орондоо авах боломжоор хангагдлаа.

•Хавдрын туяа эмчилгээнд 3 хэмжээт дүрслэлд суурилсан дотуур туяа эмчилгээг 2018 онд, шугаман хурдасгуурт суурилсан дэвшилтэт технологийг 2020 онд тус тус нэвтрүүлснээр хорт хавдрын туяа эмчилгээний чанарын хяналт сайжирч, эмчилгээний үр дүн нэмэгдсэн.

Хими эмчилгээний орчин үеийн хувь хүнд тохирсон бай эмчилгээг 2016 онд анх нэвтрүүлсэн. 2021 оны байдлаар ХСҮТ-д химийн эмчилгээнд 40 гаруй нэр төрлийн эм, тариа, бай эмчилгээний 8 төрлийн эм хэрэглэж байна. Ийнхүү эмийн нэр төрөл нэмэгдэж, хими эмчилгээний зардлыг ЭМДС-гаас санхүүжүүлдэг болсоны үр дүнд хими эмчилгээний чанар, хүртээмж сайжирч, хавдраар өвчлөгсөдийн амьдрах хугацаа уртасч, амьдралын чанар сайжирсан үр дүнтэй байна. ХСҮТ-ийн лабораторид иммуногистохимийн 30 гаруй үзүүлэлт, молекул генетикийн оношилгоогоор 6 генийн мутацийг тодорхойлон хими эмчилгээ ялангуяа бай эмчилгээ хийхэд ашиглаж байна.

2021 оны байдлаар аймаг, дүүргийн түвшинд хими эмчилгээний 65 ортой болж, жилдээ давхардсан тоогоор 1200 гаруй хүнд хими эмчилгээг орон нутагт нь хийсэн байна.

Хавдрын хөнгөвчлөх тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутгийн эмч, мэргэжилтнүүдийг чадавхижуулах ажлууд үе шатайгаар хийгдэхийн зэрэгцээ асран хамгаалагч нарт зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулж, Улаанбаатар хотын дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвүүд дээр сургалтууд зохион байгуулагдаж байна.

Хавдрын эрт илрүүлэг, тусламж үйлчилгээний талаар гарсан ололт амжилтыг энэхүү номын гуравдугаар бүлэгт дэлгэрэнгүй тусгав.

Нотолгоонд суурилсан бодлогыг хэрэгжүүлэх үүднээс хорт хавдрын судалгааг тэргүүлэх чиглэлийн дагуу эрчимжүүлэх, судлаачдыг бэлтгэж, чадавхийг бэхжүүлэхэд гадаадын түнш байгууллага болох Азийн цөмийн хамтын ажиллагааны форум, АНУ-ын Хавдрын судалгааны хүрээлэн, Сингапурын Эрүүл мэндийн группын нэгдсэн институт зэрэг байгууллагуудтай эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр хамтран ажиллаж ирлээ (дэлгэрэнгүйг дөрөвдүгээр бүлгээс харар)

2.2.2 Хөх, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн хөтөлбөрийн хэрэгжилт

Монгол улсад 2012 оноос хөх, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн хөтөлбөрийг анх хэрэгжүүлжээ. Хөтөлбөр хэрэгжсэнээс хойш умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих эмэгтэйчүүдийн 43,1% нь хамрагдаж, 610 хорт хавдрын тохиолдол илэрсэний 40% нь эрт үедээ оношилогдож эмчлэгдсэн үр дүнтэй байна.

Умайн хүзүүний болон хөхний хорт хавдрын эрт илрүүлгийн тогтолцоо бүрдүүлэхийн тулд умайн хүзүү, хөхний өмөнгийн эмнэлзүйн удирдамжийг 2011 онд анх удаа боловсруулж, 2021 онд шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлан хэрэгжүүлсэн.

Мөн умайн хүзүү, хөхний өмөнгийн

оношилгоо, эмчилгээний стандартыг Стандартчилал хэмжил зүйн газраар, Хөх, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн хөтөлбөрийн бүртгэл мэдээллийн удирдамж болох Эргэндуудах тогтолцооны удирдамжийг Эрүүл мэндийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар тус тус батлан мөрдлөг болгон ажиллаж байгаагийн зэрэгцээ хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулах сургалтыг тодорхой давтамжтайгаар зохион байгуулж ирсэн билээ.

Хавдрын эрт илрүүлгийн бүртгэл, мэдээллийг Эргэн дуудах тогтолцооны удирдамж, ЭМС-ын 2019 оны 611 дугаар тушаалаар батлагдсан "Хорт хавдар, Эрт илрүүлэг үзлэгийг мэдээлэх журам"-ын дагуу хийж байна.

Эрт илрүүлгийн үзлэгийн програм "www.screening.gov.mn" програмыг Австралийн Засгийн газрын Direct Aid хөтөлбөрт хамрагдан "Strengthening Call-Recall system of cancer screening" төслийн санхүүжилтээр өргөтгөн сайжруулж, серверийг үндэсний дата төвд байршуулсанаар мэдээний сан найдвартай, аюулгүй ажиллах боломж бүрдлээ.

2020 онд умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн эмнэлзүйн зааврыг шинэчлэн боловсруулж, ЭМС-ын А/641 тоот тушаалаар батлан мөрдөж байна.

ЭМС-ын 2018 оны А/420 тоот тушаалын дагуу умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд 30-60 насны эмэгтэйг 3 жилд нэг удаа хамруулж байна.

2.2.3 Бусад байрлалын хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн хэрэгжилт

Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль зэргийн хэрэгжилтийг хангах хүрээнд хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамруулах журмыг боловсруулж, ЭМС-ын 2018 оны А/420 тоот тушаалаар батлан эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулж байна.

Энэ журмын дагуу дараах хэлбэрээр хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг хийгдэж байна. Үүнд:

- 2) Элэгний хавдрын эрт илрүүлэг: 40 түүнээс дээш насны, гепатитийн В, С вирусийн халдвартай, элэгний архаг үрэвсэл, хатууралтай иргэнийг хорт хавдар илрүүлэх үзлэг шинжилгээнд жилд 1-2 удаа хамруулах
- 3) Ходоодны хорт хавдрын эрт илрүүлэг: 40 түүнээс дээш насны иргэнийг ходоод,

улаан хоолойн хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэг шинжилгээнд жилд нэг удаа хамруулах

- 4) Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдрын эрт илрүүлэг: 50 түүнээс дээш насны иргэнийг бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэг шинжилгээнд хоёр жилд нэг удаа хамруулах
- 5) Түрүү булчирхайн хорт хавдрын эрт илрүүлэг: Эрэгтэйчүүдийг 50 наснаас эхлэн жилд 1 удаа түрүү булчирхайн хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулахаар зохицуулагдаж, ЭМДС-гаас эрт илрүүлгийн үзлэгийг санхүүжүүлж байна.

2020 онд ходоод, элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн мэдээний санг www.screening.gov.mn програмд нэмж оруулахын тулд MsSQL to Oracle ачаалал даах орчин үеийн технологи шилжүүлж нэмэлт өргөтгөл хийх төслийг хэрэгжүүлсэнээр бүх байрлалын хорт хавдрын мэдээний сан бий болсон.

2.3 ХАВДРААС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ БОДЛОГО, ХӨТӨЛБӨР: 2020-2050 ОН

Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эрүүл мэндийн зорилтын хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны 2020-2024 оны хөтөлбөр, ЭМС-ын 2021 оны 6 дугаар

сарын 10-ны өдрийн А/360 тоот тушаалаар батлагдсан "Хавдрын эсрэг арга хэмжээний 2021-2024 оны төлөвлөгөө" зэрэг бодлогын бичиг баримтуудад хавдраас сэргийлэх, хянах, хавдрын дарамтыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг цогцоор тусган олон салбарын оролцоотой хэрэгжүүлж байна.

Засгийн газрын үйл ажиллагааны 2020-2024 оны хөтөлбөр, “Хавдрын эсрэг арга хэмжээний 2021-2024 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилт

Монгол улсын Их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т дараах 2 бүлэг заалт тусгагдсан. Үүнд:

1. “Хавдрын эсрэг арга хэмжээ” хэрэгжүүлэх
2. ХСҮТ-2 салбар эмнэлгийг байгуулах

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх хүрээнд хавдраас сэргийлэх, хянах үйл ажиллагааг салбар дундын хамтын ажиллагаанд тулгуурлан үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор “Хавдрын эсрэг арга хэмжээний 2021-2024 оны төлөвлөгөө”-г ЭМС-ын 2021 оны А/360 тоот тушаалаар батлан ажиллаж байна.

Энхүү төлөвлөгөө дараах зорилтын хүрээнд хавдраас сэргийлэх, хянах үйл ажиллагааг төлөвлөн олон салбарын оролцоотойгоор хэрэгжиж байна. Үүнд:

- Хорт хавдрын асуудлаарх бодлого, эрх зүйн орчныг сайжруулах;
- Хавдрын хяналтын урт хугацааны (2022-2032) зорилтот хөтөлбөрийг боловсруулах,
- Хавдрын эрт илрүүлгийн тогтолцоог бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх
- Хавдрын тусламж үйлчилгээтэй холбоотой удирдамж, стандарт, тушаал, заавруудыг шинэчлэх, сайжруулах, шинээр боловсруулах
- Хавдрын эрт илрүүлэгтэй холбоотой тусламж үйлчилгээний уялдаа холбоог сайжруулах, тушаал, заавруудыг шинэчлэх сайжруулах

- Хавдрын тусламж үйлчилгээг өргөжүүлэх,
- Үндэсний хэмжээнд эрт илрүүлгийн сүлжээг бий болгох,
- ХСҮТ-ийн Эрт илрүүлгийн төвийг шинээр барих, байгуулах,
- Аймаг, дүүргүүдэд хавдрын эрт илрүүлгийн төвүүдийг байгуулах
- Аймаг, дүүргүүдэд хавдрын мэс засал, хими эмчилгээний чадавхи бэхжүүлэх,
- Хавдрын судалгаа шинжилгээний чадавхи бэхжүүлэх,
- Хавдрын даван туулагчдын хөтөлбөр хэрэгжүүлэх,
- Хиймэл оюун ухаанд суурилсан дэвшилтэт технологиудыг нэвтрүүлэх чиглэлээр үйл ажиллагаанууд төлөвлөн хэрэгжүүлж байна.

Хүний хөхөнцөр вирусын халдварын эсрэг вакцинжуулалтыг нэвтрүүлэх зорилгоор ММСС-ийн Эрүүл мэндийн төслийн хүрээнд 2012 онд 2 аймаг (Өмнөговь, Сэлэнгэ), Улаанбаатар хотын 2 дүүргийн (Баянгол, Багануур) хэмжээнд 14.000 охидыг хүний хөхөнцөр вирусийн дархлаажуулалтад хамруулж үр дүнг нь судалж, цаашид уг вакциныг төвлөлд оруулахаар 2021-2024 оны Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

ХСҮТ-2 салбар байгууламжийг барих газрын асуудлыг бүрэн шийдвэрлэж, Улаанбаатар хотын СХД-ийн нутаг дэвсгэрт 8 га талбай газрын гэрчилгээг авч баталгаажуулсан. Барилгын зураг төсөл, ажлын ТЭЗҮ хийгдсэн.